

## **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

2020.03.30

Арвайхээр сум

### **НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар: АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 1 удаа хуралдаж, Ус хангамж, ариутгах татуургын хамгаалалтын бүс тогтоох тухай тогтоолд тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт (2019 оны 48\06-01), Арвайхээр суманд шинээр баригдсан цэвэрлэх байгууламжид эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох тухай, Хеликобактерийн эсрэг аян зохион байгуулах тухай, Элэг бүтэн Монгол хөтөлбөрт эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг хамруулах тухай, "Баянтээг" ОНӨХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах саналын тухай, 2020 онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хуваарь батлах тухай 6 асуудлыг хэлэлцэж, 4 тогтоол батлан, 1 асуудалд тэмдэглэлээр үүрэг өгч, 1 асуудалд албан бичиг хүргүүлж ажиллав.

"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн 13.2.1, 13.2.2 дахь заалтын дагуу нэхэмжлэгч Гучин-Ус сумын 4 дүгээр багийн иргэн Сэнгийн Төмөртогод 80.0 сая төгрөгийн нөхөх олговрыг гардууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2020 оныг "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх жил" болгон зарлаж, аймгийн ГХУСАЗСЗ-ийн зорилтот жилийн ажлын тусгай төлөвлөгөө болон салбар зөвлөлийн дэргэдэх Дэд зөвлөлүүдийн төлөвлөгөө батлагдлаа.

### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Аймгийн Засаг дарга Г.Ганболд захирамжаар Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 3 дугаар сарын 30 хүртэл сунган, аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулах болон цахим тоглоомын газар, интернэт кафе, спорт заал болон сургалтын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоогоод байна. Мөн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, сурталчилгааг хийж, ажилтнуудаа дархлаагаа дэмжих, амны хаалт хэрэглэхэд нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд хөрөнгө шийдвэрлэн ажиллахыг бүх шатны байгууллагад уриалав.

Арвайхээр сум дотор нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг "Арвайхээр нийтийн тээвэр, гэрэлтүүлэг" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 4 автобусанд Зоонозын өвчин судлалын төвөөс халдваргүйтгэл хийлээ. Мөн Арвайхээр сумын 47.000 м<sup>2</sup> нийтийн эзэмшлийн талбай, авто замын 17.000 м<sup>2</sup> талбайд ариутгал, халдваргүйтгэлийг хийж байна. Арвайхээр сумын Сууц өмчлөгчдийн холбоо, "Цуврайн гол" ХХК хамтран нийтийн орон сууцнуудын орц, хонгил, гадна зам талбайд ариутгалын ажлыг хийж гүйцэтгэв.

Дэлхий нийтийг түгшээж байгаа коронавирусын халдвараас хүн ардаа хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байгаа алба хаагчдад зориулан аймгийн Засаг даргын Тамгын газрын 70 гаруй ажилтан, албан хаагчид нэг өдрийн цалингаараа Н95 маск 100 ширхэг, 1 литрийн санитол 80 ширхэг, 275 граммын санитол 100 ширхэг, 30 граммын санитол 200 ширхэг, Татварын хэлтсийн хамт олон гар ариутгагч 10 литр, ионжуулсан ариутгагч ус 50 ширхэг, нэг удаагийн бээлий 10 хайрцаг, 330 мл спирт 30 ширхэг,

Төрийн банкны хамт олон 1.0 сая төгрөг, аймаг дахь Зүүний хүчний холбоо 1.2 сая төрөгийг аймгийн Онцгой комисст хандивлалаа.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар “Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар”, “Ус хангамж, ариутгах татгуурын хамгаалалтын бүс тогтоох тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2019 оны 48 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт”, “Арвайхээр суманд шинээр баригдсан цэвэрлэх байгууламжид эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох тухай тогтоолын төсөл”, Хеликобактерийн эсрэг аян зохион байгуулах тухай, “Элэг бүтэн монгол хөтөлбөр”-т эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг хамруулах тухай, “Өвөрхангайд үйлдвэрлэв” зорилтот жилийн ажлын төлөвлөгөөний батлах, аймгийн брэнд бүтээгдэхүүний логоны уралдаанд ирүүлсэн шилдэг бүтээлүүдийг шалгаруулах, Орон нутгийн үйлдвэрлэлийг төрийн байгууллагын худалдан авалтаар дэмжих тухай аймгийн Засаг даргын албан даалгаврын төсөл, “Бизнес мэдээлэл, бизнес инкубаторын төвийн үйл ажиллагааны журам батлах тухай” тогтоолын төсөл хэлэлцэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал, Арвайхээр сумын Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад хийсэн дотоод хяналт шалгалтын дүн, цаашид анхаарах асуудал зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Бизнес инкубаторын төв барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер, Арвайхээр сумын 2 дугаар сургуулийн спорт заалны засвар, Арвайхээр сумын төвд 150 хүүхдийн цэцэрлэг барих, Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын барилга, Уламжлалтын эмнэлэгийн барилга барих, Арвайхээр сумын 240 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөл, Хархорин сумын нийтийн орон сууцны байрны засвар, Арвайхээр сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөл зэрэг худалдан авах ажиллагааг зохион байгууллаа.

### **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ**

Улс, орон нутгийн төсвийн 43 байгууллагын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг ханган төлбөр тооцоог гүйцэтгэж 3-р сард нийт 3219 ш төлбөрийн хүсэлтээр нийт 14.8 тэрбум төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 6.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авч сарчилсан хуваарийн дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудад хуваарилан санхүүжүүлсэн. Тусгай зориулалтын шилжүүлэгээр ерөнхий боловсролын сургууль 8.7 тэрбум, хүүхдийн цэцэрлэг 4.0 тэрбум, хүүхдийн хөдөлмөр хамгааллын үйлчилгээний тусгай шилжүүлэг 102.0 сая, эрүүл мэндийн тусгай шилжүүлэг 2,0 тэрбум төгрөг, газрын, харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг 139,7 сая төгрөг санхүүжилт шилжүүлэн ажиллав.

### **ТАТВАРЫН ХЭЛТЭС**

“Татвар төлөгчийг бүртгэх журам”-ыг удирдлагын дагуу 1361 хуулийн этгээд, 746 салбар газар, төсөвт болон төрийн бус байгууллага, 28111 иргэний бүртгэлтэй нийт 30218 татвар төлөгчийн бааз суурьтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу татварын тайлангаар хөнгөлөлт, чөлөөлөлт тусган тайлагнасан ХХОАТ-ын тайланг ТЕГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 06/9 тоот чиглэлийн дагуу шалгаж баталгаажсан татвараас орлого чөлөөлүүлэх, албан татварын хөнгөлөлт эдлэх 1490 иргэнд 710,3 сая төгрөг буцаан олгохоор баталгаажуулсан.

Байгууллагын [www.tatvar.ov.gov.mn](http://www.tatvar.ov.gov.mn) сайтад тайлан ирүүлэх хугацааны талаар, алдангийн хэмжээ, НӨАТ-ын төлбөрийн баримтын талаарх зөвлөмж, ХХОАТ-ын

хуулийн нэмэлт өөрчлөлтүүд, нэхэмжлэхэд суурилсан цахим төлбөрийн системээр татвараа хэрхэн төлөх вэ, татвар төлөгчөөр бүртгүүлэхэд заавал татварын албан ирэх шаардлагагүй боллоо, татвар төлөх тайлагнах хугацаа, мэдээллүүдээр тухай бүр нь шинэчилж 8 мэдээ, мэдээлэл оруулж сайтаар сурталчилсан.

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС**

Нийгмийн даатгалын сангуудын төлөвлөгөө 7173.5 сая төгрөг гүйцэтгэл 6456.15 сая төгрөг төвлөрүүлж сангийн төлөвлөгөө 90 хувиар биелсэн байна.

Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалд бүртгэлтэй 566 аж ахуйн нэгж байгууллагад 4367 даатгуулагч иргэд, 203 төсвийн байгууллагад 7248 даатгуулагч иргэд, сайн дурын даатгалд 3086 даатгуулагч иргэд, нийт нийгмийн даатгалын албан журмын болон сайн дурын даатгалд 14701 иргэд хамрагдсан байна.

Нийт 822 даатгуулагчдад тэтгэмжийн сангаас 728,8 сая төгрөгний тэтгэмж олгов. Үүнд: ХЧТА 300 даатгуулагчдад 29,9 сая төгрөг, ЖА-375 даатгуулагчдад 498,5 сая төгрөг, Оршуулга 58 даатгуулагчдад 58.0 сая төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмж 89 даатгуулагчдад 142,4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Шинээр өндөр насны 544 тэтгэвэр авагч, 82 тахир дутуугийн тэтгэвэр авагч, 15 тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинээр тогтоосон байна.

Архивын лавлагаа 388, нэгдлийн тодорхойлолт 221, нөхөн тооцохын лавлагаа 28 лавлагаа, нийт 637 иргэн архивын лавлагаа авсан байна.

### **САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА**

Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын удирдамжийн дагуу Арвайхээр Хотын захирагчийн алба, Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-уудад дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-уудад хийгдсэн дотоод аудитын тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

### **ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн албан бичиг, удирдамжийн дагуу "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг" тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах тухай аймгийн Засаг даргын албан бичгийг сумд, холбогдох агентлагуудад хүргүүлсэн бөгөөд цахимаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг иргэдэд хүргэн ажиллав.

Авлигатай тэмцэх газраас авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2020 оны сургалтад төрийн албанд шинээр томилогдсон алба хаагчдыг хамруулахаар төлөвлөж байгаатай холбогдуулан цахим бүртгэл хийх тухай албан бичиг бүхий судалгааг сум, агентлагуудад хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

"Аймгийн Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөө"-г батлуулан, 19 сум, 21 агентлагт хүргүүлэв.

### **Архивын тасаг**

Аймгийн архивын тасагт байгууллага, иргэдээс 715 өргөдөл хүлээн авч 351 лавлагаа, 1296 хуулбар, 130 тодорхойлолт олгоод байна.

“Архивын тоо бүртгэл, эрэл хайлтын праграмм”-д 92 хадгаламжийн нэгжийн 8935 хуудас, 5757 заалт, 40652 хүний нэр, 5553 байгуулагын нэр, 5347 газар зүйн нэр бүхий захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

“Архивчдын өдөр”-ийг тэмдэглэх ажлын хүрээнд уламжлалт “Бидний бахархал” сэдэвт өдөрлөг зохион байгуулж, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн, ажил мэргэжлийн уралдаан баримтын үзэсгэлэн зохион байгуулж, тэргүүний ажилтнуудыг салбарын болон бусад шагналаар шагнаж урамшуулав.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн дүн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцүүлж, нийт төвийн захирагч нарт хуралдааны тэмдэглэлээр үүрэг даалгавар өгч, аймгийн Засаг даргын А/793 дугаар захирамжаар ажлын үр дүнг харгалзан шагнаж урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэв.

### **ЦАГДААГИЙН ГАЗАР**

Цагдаагийн газарт 03 дугаар сарын байдлаар 1145 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь 7 буюу -0.6 хувиар буурсан, үүнээс гэмт хэргийн шинжтэй 144, зөрчлийн шинжтэй 1001 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 99 холбогдогчтой, 179.0 сая төгрөгийн хохиролтой, 104 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 93 хэргээр буюу -47.2 хувиар буурсан, хэргийн илрүүлэлт 38.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс +20.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хэргийн төрлөөр: - Залилах гэмт хэрэг 10 бүртгэгдэж, 1-ээр буюу +2.2 дахин, бусад гэмт хэрэг 3 бүртгэгдэж, 2-оор буюу +2.0 дахин тус тус өсч, - Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 23-аар буюу -5.6 дахин, -Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 6 бүртгэгдэж 8 буюу -2.3 дахин, - Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг 3 бүртгэгдэж, 5 буюу -62.5 хувиар, - Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 39 бүртгэгдэж 10-аар буюу -20.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мал хулгайлах гэмт хэрэг 15 бүртгэгдэж 10 буюу -40.0 хувиар, Иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 10 бүртгэгдэж, 22 буюу -68.7 хувиар, - Авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 2 буюу -28.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчил өмнөх оноос 1875 буюу +24.9 хувиар өссөн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил урд оноос -78 буюу -21.6 хувиар буурсан байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, олон нийтийн эргүүл, байнгын пост, цагийн менежменттэй постуудыг ажиллуулснаар тодорхой үр дүнд хүрч байгаагаар тодорхойлогдож байна.

### **ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР**

“Covid-19” холбоотойгоор аймгийн Эрүүл мэндийн газраас сум, өрхийн цахимаар 5 удаагийн сургалт зохион байгуулагдав.

Шинэ коронавирусээс сэргийлэх зөвлөгөө өгөх 94997721 утсыг ажиллуулж, мэргэжилтнүүд хуваарийн дагуу зөвлөгөө өгч, өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн хариуцлагатай жижүүрийн үүргийг 24 цагаар гүйцэтгэж байна.

Коронавирусын халдварт өвчний талаарх мэдлэг, өвчнийг оношлох, эмчлэх, сувилах, асрах, урьдчилан сэргийлэх мэдлэг чадвар, хандлагыг дээшлүүлэх

сургалтыг Бүсийн оношлогоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн ортой эмнэлэг зэрэг нийт 27 байгууллагын 1142 ажилтан, албан хаагчдад зохион байгууллаа.

Аймгийн Засаг Даргын 2020 оны 103 дугаар захирамжаар хавьтагсдыг тусгаарлах, ажиглах байрыг сонгож, 641 орыг бэлтгэж, бэлэн байдлыг хангахаар /Политехникийн коллежийн оюутны 2-р дотуур байр, 11 зочид буудлын 341 ор, 1-р сургуулийн дотуур байр-100 ор, нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд спорт зал, цэцэрлэгүүдийг дайчлахаар/ төлөвлөн, мэргэжлийн заавар, зөвлөмжөөр хангасан.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн илрүүлэг шинжилгээ, эмчилгээнд хамрагдалт, нэн ядуу иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах зорилгоор 3165 нэн ядуу иргэдийн илрүүлэг шинжилгээний түргэвчилсэн оношлуурын зардлыг орон нутгийн зардлаар шийдвэрлэн ажиллав.

### **БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГ**

Өвөрхангай аймаг, Франц улсын Альер мужтай хамтын ажиллагааны 20 жилийн ойн хүрээнд Францын Ганна хотын хөгжмийн фестивалд оролцох ардын авъяастнуудын тоглолтын бичлэгийг хийж, хүргүүлэв.

Боловсролын салбарын албан хаагчдын дунд "1 хүн-2 маск" аяныг санаачилан хэрэгжүүлж, 2440 ширхэг амны хаалт цугларсныг аймгийн онцгой комисст 2005 ширхэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 435 ширхэгийг хүлээлгэн өгөв.

Хорио цээрийн үед цэцэрлэгийн хүүхдийн ариун цэврийн хэрэгслийн хэрэглэгдээгүй 2 сарын хэрэглээг зорилтот өрхөд хүргүүлэх аяныг санаачилан зохион байгуулж, хүргүүллээ.

Ерөнхий боловсролын 12 дугаар ангийн сурагчдын дунд элсэлтийн ерөнхий шалгалтын "Онлайн сорилго-2020" арга хэмжээг 3 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 4 дүгээр сарын 4-ний өдөр хүртэл зохион байгуулж байна. Цахим сорилгод 26 сургуулийн 985 сурагчийн судалгааг нэгтгэн кодолж цахимд байршуусан ба сурагчдын кодыг зөвлөмж зааврын хамт сургууль бүрт хүргэлээ.

### **ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ**

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд нийт 123 шинэ ажлын байр бүртгэсэн. Үүний 120 нь байнгын, 3 нь түр ажлын байр байна. Шинээр бий болсон ажлын байрыг эдийн засгийн салбарын ангилалаар авч үзвэл хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур 5.0 хувь, боловсруулах үйлдвэрлэл 19.1 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ 18.3 хувь, зочид буудал, байр сууц, хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа 28.3 хувь, бусад салбарт 15.8 хувь байна.

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системд шинээр ажил хайгч 70 иргэний мэдээллийг бүртгэж, бүртгэлтэй боловч идэвхгүй төлөвт шилжсэн 120 иргэний мэдээллийг идэвхжүүлсэн.

Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагаас 78 ажлын байрны захиалга хүлээн авч, 74 иргэнийг ажлын байранд зуучилсан. Дээрх иргэдийн 43 нь буюу 58.1 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид, 31 буюу 41.9 хувь нь төрийн байгууллагад ажилд орсон байна.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн стартап арга хэмжээ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгүүдэд хамрагдах

хүсэлтэй иргэдийг бүртгэж, 19 сумын 252 иргэний төслийг хүлээн авч үйл ажиллагаатай нь танилцан, нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.

Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 155.0 сая төгрөгийн санхүүжилт авч 442 иргэнд 148.9 сая төгрөгийг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 40.0 сая төгрөгийн санхүүжилт авч 1072 иргэнд 40.0 сая төгрөгийг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 30.0 сая төгрөгийн санхүүжилт авч 290 иргэнд 28.7 сая төгрөгийг олголоо. Ахмад настаны нийгмийн халамжийн үйлчилгээнд 140.0 сая төгрөгийн санхүүжилт авч 5809 иргэнд 129.3 сая төгрөгийг, цалинтай ээж хөтөлбөрт 280.0 сая төгрөгийн санхүүжилт авч 5571 иргэнд 279.6 сая төгрөгийг, ихэр хүүхдийн тэтгэмжид 12.0 сая төгрөгийн санхүүжилт авч 4 иргэнд 8.0 сая төгрөгийг, алдар цолтон ахмад настаны тэтгэмжид 13.0 сая төгрөгийн санхүүжилт авч 37 иргэнд 12.0 сая төгрөгийг, өрх толгойлсон эх,эцгийн тэтгэмж 3 иргэнд 695.6 мянган төгрөг, алдарт эхийн одонгийн мөнгөн тэтгэмжид 1323.3 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 9504 иргэнд 1230.3 тэрбум төгрөгийг, насны хишгийн мөнгөн тэтгэмжид 5031 иргэнд 424.4 сая төгрөгийг, хүнс тэжээл хөтөлбөрт 110.0 сая төгрөгийн санхүүжилт авч 4716 иргэнд 114.0 сая төгрөгийг, банкны шимтгэлд 2.1 сая төгрөгийн санхүүжилт авч 1.2 сая төгрөгийг тус тус зарцуулж нийт 36205 иргэнд нийт 4011.4 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс 28.0 сая төгрөгийн санхүүжилт авч 8 иргэнд 7.2 сая төгрөгийг олгосон байна.

“Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зорилтот бүлгийн өрх, иргэдийг COVID-19-ын халдвараас хамгаалах зорилгоор Богд сумын ЗДТГ “Нэг өрх 5 маск” , Баянгол сумын “Залуучуудын холбоо”, “Залуус хөгжлийн хүрд” ТББ хамтран “Залуучууд Ковид 19-ийн эсрэг нэгдэж байна” аяныг тус тус зохион байгуулж 125 ширхэг амны хаалт, 100 ширхэг витаминь зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй олгосон.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний хүрээнд 902 өрхийн 4744 иргэнд 57.5 сая төгрөгийн цахим эрхийн бичгийг олгосон.

### **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД**

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 25-ны А/330 тоот тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам"-ын дагуу 2020 онд шинээр магадлан итгэмжлэлд хамрагдах, хугацаа сунгах ажлыг зохион байгуулж, "Монголын Эмэгтэйчүүдийн холбоо "Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл", Өвөрхангай аймаг дахь "Хүчирхийллийн Эсрэг Төв"-ийн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан "Залуучууд коронавирүсийн эсрэг нэгдэж байна" үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж 4 төрлийн танилцуулга зөвлөмж хэвлэж 42 үйлчилгээний байгууллага 9 нийтийн эзэмшлийн орон сууцны хаалга, мэдээллийн самбар дээр байршуулж, мэдээлэл өгсөн. Мөн "1 залуу-10 маск" challenge өрнүүлж, одоогийн байдлаар 18 залуу нэгдэж 180 маск цуглаад байна.

COVID19 вирусын халдварын нөхцөлд гэртээ байгаа хүүхэд багачуудын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авъяас чадвараа хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох эрхийг нь хангах үүднээс гар зураг, захидал, эссе бичлэгийн уралдааныг зарлан, зохион байгуулж байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/71, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/115, Эрүүл мэндийн сайдын А/155 тоот 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хамтарсан тушаалаар батлагдсан "ХҮҮХЭД ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ" аяны хүрээнд миний гэр аюулгүй орчин үнэлгээний хуудсыг цахимаар

тарааж, байгууллага, иргэд, найз нөхөд болон өөрийн гэрийн аюулгүй байдлыг үнэлэхийг уриалж, байгууллага, ААН-ийн дэргэдэх Гэр бүлийн зөвлөлүүдэд чиглэл өгөв.

### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бүтэц зохион байгуулалтаар Мал эмнэлгийн газар байгуулагдсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн газрын "Өмч хамгаалах зөвлөл" ажиллаж байгууллагын өмч хөрөнгийг бүртгэн баталгаажуулав.

Аймгийн Засаг даргын 2020 оны "Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай" А/89 дүгээр захирамжийн дагуу үлийн цагаан оготнотой микро-биологийн аргаар тэмцэх ажлыг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн "Нийтийг хамарсан ажил"-ийн хүрээнд хамтран зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү захирамжийн дагуу сумдад албан тоот хүргүүлэн бэлчээрийг чөлөөлөх, ажиллах хүн хүчний судалгааг гаргах, бактержуулсан будаа нийлүүлэх аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан, ирүүлсэн будааг сумдад тараах зэрэг бэлтгэл ажил хийгдэж байна.

Аймгийн хэмжээнд 19 сумын 16398 малчин өрхийн 2.2 сая гаруй хээлтэгч тоолуулснаас мал хээлтүүлгийн мэдээгээр 1.8 сая орчим мал төллөх дүн мэдээтэй байна. Хээл хаялтын мэдээгээр төллөсөн хээлтэгч 77673, хорогдсон төл 1749, бойжиж буй төл 75924, мал төллөлт 3.4 хувьтай байна. Том малын хорогдол 17050, хээл хаялт 4839 гэсэн дүн мэдээтэй байна.

Улс, аймгийн онцгой комиссоос хагас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг сум бүрээс авч боловсруулалт хийж Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Улсын онцгой комисс, аймгийн онцгой комисс, Мэргэжлийн хяналтын газарт 7 хоног бүр хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээгээр нийт тариалах талбай 10655 га, үр тариа 7110 га үүнээс буудай 6800 га, арвай 150 га, овъёос 160 га, малын тэжээл 980 га, тосны ургамал 1000 га, төмс 391 га, хүнсний ногоо 255 га-д тус тус тариалах бөгөөд хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд: 2020 оны хаврын тариалалтад шаардагдах үрийн улаан буудайн нөөц, хэрэглээ, тариалах талбайн судалгаа, хүлэмжийн захиалгыг авч Хөдөө аж ахуйн дэмжих санд хүргүүлсэн.

### **ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

Өмчийн асуудлаар 1 сард 18 сумын 150 төсөвт байгууллагуудын "Орон нутгийн өмч эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн.

Мөн Үндэсний статистикийн газраас гаргасан маягт, журмын дагуу орон нутгийн өмчит 179 байгууллагын үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлийн статистик мэдээг 3 сарын 10-ны дотор нэгтгэн хүргүүлж орон нутгийн өмчит 179 байгууллага 82 сангийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан, авто тээврийн хэрэгслийн судалгаа, 1999 оноос хойш хувьчлагдсан худалдсан, хуулийн этгээд, үл хөдлөх хөрөнгийн судалгааг нэгтгэн хүргүүлэхээс 82 байгууллага 51 сангийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан, авто тээврийн хэрэгслийн судалгааг нэгтгээд мэдээллийг Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүрэн оруулсан.

Худалдан авах ажиллагааны алба нь “Баянтээг” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээ, “Баянтээг” ХК-д 2020 онд хэрэглэгдэх дизель түлш, шатах тослох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер, Арвайхээр сумын 2 дугаар сургуулийн спорт заалны засвар, Арвайхээр сумын төвд 150 хүүхдийн цэцэрлэг барих, Төв номын сангийн хуучин барилгын засвар, Бизнес инкубаторын төв барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер, Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын барилга, Есөнзүйл сумын төвөөс орон нутгийн А-0301 Засмал зам хүртэлх 10.0 км цахилгаан дамжуулах агаарын шугам, Уламжлалтын эмнэлэгийн барилга барих, Арвайхээр сумын 240 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөл, Хархорин сумын нийтийн орон сууцны байрны засвар, Арвайхээр сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөл, Шинээр ашиглалтад орох боловсрол, соёл, спортын байгууллагуудад тавилга, тоног төхөөрөмж худалдан авах, усан спорт, сургалтын төвийн фитнесийн тоног төхөөрөмж, Музейн барилга, Хужирт сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилга зэрэг 17 тендер зарлаад байна. Нийт тендер шалгаруулалтын 70.5% нь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 29.5% нь тендер шалгаруулалтын онцгой журмын дагуу зохион байгууллаа.

### **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Байгаль орчин аялал жуулчлалын газраас Хужирт сумын нутаг Дулаан уул, Хангуйн мухар орчим халиун буганд биотехникийн арга хэмжээ авах ажлыг тус сумын ЗДТГ-тай хамтран зохион байгууллаа.

Богд сумын ЗДТГазар, Монгол сафари, ХХКомпани Эрхэм Баян хайрхан нөхөрлөл хамтарсан ажлын хэсэг "Арц богд" агнуурын бүс нутгийн 12 цэгт аргаль, янгирт хужир шүү тавьж өгөх ажлыг зохион байгуулж байна.

Мэдээлэл сургалт, сурталчилгааны чиглэлээр дэлхийн Ой, Ус, Байгалийн амьтан ургамлыг хамгаалах өдрийг тохиолдуулан орон нутгийнхаа байгалийн ан амьтан, ургамал, ой, усны гайхамшгийг гэрэл зураг, бичвэр ашиглан олон нийтэд сурталчлах, хайрлан хамгаалах мэдрэмж, идэвх, сонирхлыг төрүүлэх зорилгоор цахим уриалгын уралдааныг иргэдийн дунд зарласан.

Бат-Өлзий суманд Ойн тухай хууль тогтоомж зөрчигдөж гэмт хэрэг ихсэж байгаа шалтгаан нөхцлийг тодруулж түүнээс урьдчилан сэргийлэх, Ойн тухай хууль, Ойгоос мод бэлтгэх журам, уламжлалт аргаар мод бэлтгэхэд зөвшөөрөл олгож байгаа байдал, ой ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын чиглэлээр шинээр байгуулагдсан Экологийн албаны Цагдаа нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

“Хог хаягдлын чиглэлээр монголын тандан судлаачдын холбоо” ТББ-тай хамтран “Хархорин сумын хог хаягдлын менежментийг сайжруулж, иргэдийн дадал хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажлыг зохион байгуулж сайн түршлага бий болгох” төслийн хэлэлцүүлгийг Хархорин суманд зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө уралдааны удирдамжийг боловсрууллаа.

Уул уурхай чиглэлээр Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 17 дугаар тушаал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/93 дугаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхайн яам, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг тус аймагт 2020 оны 03 сарын 23-25-ны өдрүүдэд ажиллаж ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн баримт



бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд холбогдох мэдээллийг нэгтгэн гаргаж өгсөн.

### **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах тухай хүсэлт ирүүлсэн 5, газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлт 11, газар эзэмших гэрээ байгуулах, гэрчилгээ олгох хүсэлт ирүүлсэн 13, иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийг тус тус хүлээн авч шийдвэрлэж газрын цахим мэдээллийн сан, улсын бүртгэлд бүртгэн баталгаажуулж, Land manager програмд 8 нэгж талбарын мэдээллийг нөхөн орууллаа.

Арвайхээр сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөд туссан 175 айлын хаус хороололд газар эзэмших эрх шинээр авсан 1 иргэнд нэгж талбар, барилгын хил зааг, эргэлтийн цэгийг газарт буулгах хэмжилтийг хийж тэмдэгжүүлсэн.

Арвайхээр сумын 50 ортой эмнэлэг, Усан спортын барилгын ажилд техникийн хяналт хийж, алдаа зөрчлийг арилгуулах үүрэг даалгаврыг өгч биелэлтийг хянан ажиллаж байна.

Аймгийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний өнөөгийн мэдээлэл болон улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр сүүлийн 3 жилд хэрэгжсэн төсөл арга хэмжээ, 2021 оны улсын төсөв болон 2020-2030 оны төсөөлөлд тусгуулах ажлын санал зэрэг мэдээлэл, судалгааг хавсралтад заасан маягтын дагуу гаргаж, мөн барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм"-ийн өөрчлөлтөнд оруулах санал, аймгийн товч танилцуулгыг бичин фото зураг, тайлбар, "150 мянган айлын орон сууц", "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн биелэлтийг гарган тус тус БХБЯаманд хүргүүлэв.

Хайрхандулаан сумын "Сумын төвийн шинэчилэл" төсөлд хамрагдах инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тусгах саналын 2 дахь хувилбарыг дахин боловсруулж, томсгосон төсвөөр тооцооллыг хийж холбогдох удирдлагуудад танилцуулж, одоо ашиглагдаж байгаа инженерийн шугам сүлжээний хэмжилтийг хийлгэн мэдээллийн санд оруулав.

Сант суманд баригдах 240 хүүхдийн сургууль, Хайрхандулаан суманд баригдах ЗДТГазрын барилгын дулаан, цэвэр, бохир усны техникийн нөхцлийг гарган баталгаажуулж мөн Арвайхээр суманд баригдах 320 хүүхдийн сургууль, Музейн барилга, Хайрхандулаан суманд баригдах ЗДТГазрын барилгын зургийн гэрээний төслийг боловсруулж холбогдох зургийн компаниудад хүргүүлэв. Уянга сумын үерийн сувгийн зураг төсөл боловсруулах гэрээг холбогдох материалыг бүрдүүлэн байгуулав.

Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичигт хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний судалгааны манайд хамааралтай заалтын биелэлтийг гарган ХОХБТХэлтэст, Өвөрхангай аймагт 2019 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төслүүдэд аудит хийхээр ирүүлсэн судалгааг холбогдох маягтын дагуу гаргаж, холбогдох төслүүдийн бичиг баримтыг жагсаалтаа Аудитын газарт тус тус хүргүүллээ. Арвайхээр суманд баригдаж байгаа "Усан спортын цогцолборын барилга, байгууламж"-д нэмэлт хөрөнгийн асуудал шийдэх хуралд оролцож санал өгөв.

### **МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР**

Ийлдэс судлалын лабораторид адууны халдварт цус багадах өвчний тандалт шинжилгээнд Бүрд, Хайрхандулаан, Нарийнтээл, Гучин-Ус, Бат-Өлзий, Баян-Өндөр,

Сант сумдаас ирсэн 100 ийлдсийн дээжинд нэвчин тунадасжих урвалаар эсрэг бием илрээгүй.

Шимэгч судлалын лабораторид Сант, Тарагт, Арвайхээр, Уянга, Баянгол, Хайрхандулаан, Өлзийт, Бат-Өлзий сумдын 40 дээжинд цагаан хорхойн шинжилгээ хийхэд эймериоз, стронгилиодоз, монезиоз, нематодериоз, стронгилиозын үүсгэгч илэрсэн. Төгрөг сумын 2 дээжинд адууны нийлүүлгийн өвчин, бабезиозийн шинжилгээ хийхэд үүсгэгч илрээгүй.

Нян судлалын лабораторид давхардсан тоогоор 19 сумын 63 дээжинд шинжилгээ хийхэд Нарийнтээл, Баян-Өндөр, Бүрд сумд үхэр- 3, Арвайхээр хонь-1, Баян-Өндөр хярс -1 галзуу өвчин, Уянга, Хархорин, Зүүнбаян-Улаан, Арвайхээр хонь-4, Өлзийт, Бат-Өлзий, Уянга хонь-3, ямаа-1 колибактериоз оношлогдсон.

Ариун цэврийн лабораторид Арвайхээр сумын Буянхурд, ӨВ ЭКО-МИЙТ ХХК-с ирүүлсэн үхрийн махны 2, хонины махны 2 дээж, иргэн Б.Гантулгын ирүүлсэн дайвар бүтээгдэхүүний 1 дээж, нийт 5 дээжинд шинжилгээ хийхэд хөлдөөж хадгаласан шинэ мах болохыг шинжилгээгээр батлав. Мөн ӨВ ЭКО-МИЙТ ХХК-с ирүүлсэн 2 махны дээжинд антибиотикийн үлдэгдлийн шинжилгээ хийхэд антибиотикийн үлдэгдэл илрээгүй.

Сумдын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдэд мал, амьтны шилжилт хөдөлгөөний талаар мэргэжил арга зүйгээр хангаж, отор нүүдэл буцаж ирэх хугацаа судалгаа авч ажиллаа

Жижиг амьтны өрөөг тохижуулан, үйл ажиллагааг жигдлэн явуулж байна. 3 сард жижиг амьтаны амбулаторид 5 өвчнөөс сэргийлэх хам вакцин 6 нохой, хордлого тайлах болон бусад эмчилгээ, үйлчилгээг 13 нохой, хээлийн хүндрэлтэй 1 хонь, үений үрэвсэлтэй 1 адуу, тэжээл боловсруулах эрхтэний өвчилөлтэй 3 хонинд эмчилгээ хийгдсэн байна.

Мал, амьтны сэг зэмийг өвөлжөө, хаваржаа, хашаа хорооноос 500 метрээс доошгүй зайтай газарт автомашин, ус үерийн замаас зайдуу гүн нүхэнд булах буюу шатааж устгах ажлыг зохион байгуулах хүн, машин техник, явах маршрут гаргах, устгах цэгийг тогтоох судалгааг 19 сумаас авч нэгтгээд байна. Үүнд: 448 цэгийн 21118 мкв талбайд халдваргүйтгэл хийхэд 329 хүн, 71 авто машин хлорын шохой 350 кг, hi-Cop 50 кг, супер килл 80 кг бодис зарцуулагдахтооцоо судалгаа гарсан.

### **УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар -3.8 градус хүйтнээс 1.8 градус дулаан байлаа. Агаарын хамгийн бага температур -15 -25 градус, хөрсөн дээр -16 -29 градус хүрч хүйтэрсэн. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж температуртай харьцуулж үзэхэд нийт нутгаар 5-8 градусаар дулаан байсан. Цасны зузаан: Хужирт, Зүүнбаян-Улаан, Уянга сумдын хойд хэсгээр 2-6 см зузаан /хунгар газартаа 10-25 см / тарлан цастай. Бусад сумдын нутгаар цасгүй байна. Бүх сумдад малд нэмэгдэл тэжээл өгөх бог мал төллөх ажил үргэлжлэн явагдаж байна.

Хангай нурууны зүүн хойт хажуугаас эхтэй Орхон гол нь халиа гүйсэн мөсний зузаан Бат-Өлзий сумын орчим 147см буюу олон жилийн дунджийн орчим байгаа бол Хархорин сумын орчим мөсөн дээгүүр ус урссан мөсний зузаан 90 см буюу олон жилийн дунджийн орчим байна.

Байгаль орчны шинжилгээний лаборатори нь Арвайхээр хотын агаарын чанарын хяналт шинжилгээг хөтөлбөрийн дагуу хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосонцорын агууламжийг 2020 оны 03-р сард нийт 46 сорьц авч тодорхойллоо.

Арвайхээр сумын агаарын чанарын үзүүлэлтээр хүхэрлэг хийн /SO<sub>2</sub>/ агууламжийн дундаж 21 мкг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 87 мкг/м<sup>3</sup>, азотын давхар

ислийн /NO<sub>2</sub>/ агууламжийн дундаж 24 мкг/м<sup>3</sup> хамгийн их 78 мкг/м<sup>3</sup> байгаа нь АЧС/агаарын чанарын стандарт/ дахь хүлцэх агууламжтай харьцуулахад давсан бохирдолгүй, нийт тоосонцорын агууламжийн дундаж нь 153 мкг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж нь 540 мкг/м<sup>3</sup> байна. 8 удаа АЧС/агаарын чанарын стандарт/ -аас 1-2 дахин давсан бохирдол ажиглагдсан.

Усны чанарын хяналт шинжилгээг Орхон голын Хархорин хяналт-шинжилгээний 1 цэгээс усны сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо. Шинжилгээний дүнгээс үзэхэд голын усны эрдэсжилт 215,9 мг/л бохирдуулах бодисын агууламж стандартын дагуу байна.

### **СУМДЫН МЭДЭЭЛЭЛ**

Зүүнбаян-Улаан суманд Хариуцлагатай хэрэглэгч сэдвийн дор хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах төлөвлөгөөг гарган, иргэдэд сурталчлан, цахимаар хүүхдүүдийн дунд уралдаан зохион байгуулж дүгнэсэн байна.

Баруунбаян-Улаан суманд энэ сард төл бойжилт 95.7 хувь, нийт төлөлт 27.8 хувьтай байна.

Есөнзүйл сумын Онцгой комисс 5 удаа хуралдаж, шуурхай штаб 24 цагаар, эргүүл 6 цагаар, автомашинтай иргэд 12 цагаар ажиллуулав. Давхардсан тоогоор 46 тээврийн хэрэгсэл, 273 албан хаагчид ажиллан, 2.2 сая төгрөгийг зарцуулсан байна.